



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/182

Арвайхээр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр өргөтгөсөн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хаваржилт хүндэрсэн сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд дахин татан авсан өвс тутамд 7000 төгрөгийн үнийн дэмжлэг болох 104,629,000 (нэг зуун дөрвөн сая зургаан зуун хорин есөн мянга) төгрөгийн зардлыг 1 дүгээр, Монголын бурхан шашны төв-гандантэгчэнлин хийдээс хандивласан 11 тонн тэжээлийн тээврийн хөлс 2,000,000 (хоёр сая) төгрөг, Бүрд, Баруунбаян-Улаан сумдад хүргэсэн 950 боодол өвсний тээврийн хөлс 3,300,000 (гурван сая гурван зуун мянга) төгрөг, Монгол Улсын Засгийн газраас 120 тонн гурил, 60 тонн цагаан будаа үнэгүй олгосны тээврийн хөлс 8,262,000 (найман сая хоёр зуун жаран хоёр мянга) төгрөгийн зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 118,191,000 (нэг зуун арван найман сая нэг зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг зохион байгуулж, өвс, ногоон тэжээл нийлүүлсэн иргэн аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан, татан авах ажлыг шуурхай явуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0382

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 13-ны өдрийн 1132 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



### ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (мянган төгрөг)
1	Улаанбаатар хотоос тусламжийн хорголжин тэжээл татан авах	11 тонн		2,000,000
2	Бүрд сумруу тусламжийн өвс хүргэх	500 боодол	3000	1,500,000
3	Баруунбаян-Улаан сумруу тусламжийн өвс хүргэх	450 боодол	4000	1,800,000
4	Монгол Улсын Засгийн газраас олгосон 120 тонн гурил, 60 тонн цагаан будаа	180 тонн	45900	8,262,000
Нийт				13,562,000

-оОо-

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 13-ны өдрийн 718 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



### ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сумын нэр	Сумдын хүлээн авсан өвсний тоо	Нийт үнэ (мянган төгрөг)	Өвс нийлүүлсэн аж ахуй нэгж
1	Баруунбаян-Улаан	400	2800.0	Т.Адъяадорж
2	Гучин-Ус	1051	7357.0	Гучингийн хөсөг ХХК
3	Есөнзүйл	1470	10290.0	Б.Долгоржав
4	Есөнзүйл	800	5600.0	Э.Өсөхбаяр
5	Баян-Өндөр	1824	12768.0	Б.Долгоржав
6	Баянгол	1750	12250.0	П.Давааням
7	Нарийнтээл	1780	12460.0	Б.Долгоржав
8	Арвайхээр	2078	14546.0	Г.Нэргүй
9	Хайрхандулаан	1454	10178.0	Өв баян борх ХХК
10	Сант	1800	12600.0	Э.Мядаг
11	Өлзийт	540	3780.0	Э.Өсөхбаяр
		14947	104629.0	

-оОо-